



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/228

Булган сум

Мал, амьтны сэг зэм устгах, ариутгал,  
халдваргүйтгэлийн ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, ерөнхий малын эмчийн 2026 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/29 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд өвөлжилт, хаваржилтын хүндрэлээс үхэж хорогдсон мал, амьтны сэг, зэмийг устгах, бэлчээр, хашаа хороо, өвөлжөө, хаваржаа болон худаг, уст цэгийн орчныг цэвэрлэж ариутгал, халдваргүйтгэл хийх ажлыг 2026 оны 04 дүгээр сарын 15-наас 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд чанартай зохион байгуулсугай.

2.Дээрх ажилд мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т, мал амьтны сэг, зэмийг устгах, халдваргүйтгэлийн ажилд хүн хүч, машин техник, бусад шаардлагатай зүйлээр хангаж малчид, багийн дарга нарыг үүрэгжүүлэн ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (О.Ундрах) –д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010292